

There are no translations available.



Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн тэргүүтэй толоологчид 2018 оны 5 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад ажлын айлчлал хийв. Тус ажлын айлчлалын зорилго нь Вьетнам Улс Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан туршлага судлахаас гадна Вьетнамын зах зээлд мах, махан бүтээгдэхүүн экспортлох манай зорилтыг бодит ажил хэрэг болгон урагшлуулахад чиглэгдсэн болно.

Толоологчдийн бүрэлдэхүүнд Гадаад харилцааны яам, Хvнс, ходоо аж ахуй, хонгон үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын еронхий газар, Гаалийн еронхий газраас тус тус толоолол оролцов.

Ажлын айлчлалын хүрээнд Төрийн нарийн бичгийн дарга Вьетнамын Гадаад хэргийн дэд сайд Ле Хоай Чунг, Аж үйлдвэр, худалдааны дэд сайд богоод Вьетнамын чөлөөт худалдааны хэлэлцээрийн яриа хэлэлцээний үндэсний багийн ахлагч Чан Куок Кхань-тай уулзаж, хоёр орны худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг оргожүүлэх боломжууд, чөлөөт худалдааны хэлэлцээр хийх явцад анхаарах зарим асуудлуудаар дэлгэрэнгүй санал солилцов. Вьетнамын Аж үйлдвэр, худалдааны яамны чөлөөт худалдааны хэлэлцээрийн яриа хэлэлцээний багийнхан дээрх Хэлэлцээрийн хэрэгжилт, эдийн засгийн ач холбогдол, гаалийн тарифын хонгололт, бараа бүтээгдэхүүний стандартын асуудлаарх яриа хэлэлцээний туршлагаасаа хуваалцав. Вьетнамын эдийн засаг сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаа богоод Зүүн Олнод Азийн орнуудаас ОХУ, Казахстан, Киргиз, Армен, Беларусь Улсыг нэгтсэн 182.7 сая хэрэглэгчтэй, 2.2 их наяд ам.долларын ДНБ-тэй том зах зээл бүхий Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан анхны улс гэдгээрээ онцлог юм.

Мөн Ходоо аж ахуй, ходоогийн хөгжлийн дэд сайд Ву Ван Там-тай уулзаж Монгол Вьетнамын ЗГХК-ийн 16 дугаар хуралдааны протоколын дагуу мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хяналт хийх хоёр талын эрсдлийн үнэлгээний ажлын багийг 8,9 дүгээр сард

ГХЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ХАНОЙ ХОТНОО АЖИЛЛАВ

Written by hanoi

Tuesday, 26 June 2018 03:37 - Last Updated Tuesday, 26 June 2018 03:40

багтаан харилцан солилцохоор болов. Манай толоологчдийг Вьетнамын Бак Нинь мужийн Дабако группийн еронхий захирал БНСВУ-ын Ходолморийн баатар Нгуен Суан Туан хвлээн авч уулзан, тахианы мах, махан бүтээгдэхвнн боловсруулах вйлдвэрээ танилцуулав.

Торийн нарийн бичгийн дарга Хай Фонг хотын Ардын Хорооны дарга Нгуен Ван Тунг, тус хотын Гаалийн еронхий газрын удирдлага болон Хай Фонг боомтын удирдлагатай уулзаж, боомтын вйл ажиллагаа, гвн холдоосон мах махан бүтээгдэхвнний чингэлэгийн терминалтай танилцав.

Ажлын айлчлалыг Европын Холбоотой хамтран хэрэгжүүлж буй Худалдааг дэмжих “ТРАМ” тослийн дэмжлэгтэйгээр Ханой дахь Элчин сайдын яам, Вьетнамын Аж вйлдвэр, худалдааны яам, Ходоо аж ахуй, ходоогийн хогжлийн яамтай хамтран зохион байгуулав.